

ДАЛД УХАМСАР

О.Лхагва, ШУ-ны доктор, профессор
физикч онолч, математикч

Abstract: In the Great Steppe, ancient Mongolian nomads have developed singular culture that has been served as fundamental bases for frequently emergence of famous Empires. From the main view point and paradigm of western classical science, it has not been well-recognized due to the cultural remnant scarcity left by nomads. It seems that the mystery of nomadic civilization has been remained still unsolved up to the present.

This article discusses that the conceptions of modern quantum physics and synergy have been originated from the peculiarities of nomadic peoples who have been maintaining harmonious relationship with their ancestors' souls and cosmic mind [1,2,3]. While coming into the transcendental soul reality and equally belonging to the periods in the past, present and future, the whole nomadic nation has acquired abilities to be integrated into the cosmic and land information sources. The intuitive awareness has promoted the proper development of nomadic culture, knowledge and sciences that kept its enigmas unrevealed up to the present day. The knowledge and traditions of spiritual, intuitive and oral science have been implemented in the unaffected nomadic Science - MunkTengery.

Түлхүүр үг: Мөнх Тэнгэр, сүнс, дээдсийн онгод, билиг энерги-мэдээлэл

Физик төсөөлөл: XX зуунд шинээр цогцолсон физик эрдмийн чиг үзэл санаанаас үргэхээ больж, харин ч олны үзэл бодол бодист уяатай сэтгэлгээнээс алгуур алсалж, Орчлонгийн язгуур оршихуй бол чухамдаа хилийн чинадад бидний хувьд “хориотой”

ертөнцийн энерги - сүнс оршихуй болохыг сонирхох болжээ. Далд ухамсар, энергийн тухай асуух, тайлбарлаж бичихийг хүсэх нь бас ч чамламгүй. Тиймээс ард түмний буян, монголынхоо нэрээр их эрдмийн газар шавилан суусныхаа ачийг бодож физикийн ололт, үзэл санаанаас соёолж тэрлэсэн хувийн бодлоо олонтой хуваалцахыг эрмэлзэв.

Далд ухамсар гэх нь өрнийн материалист гүн ухаанаас угшилтай гэмээр нэрэлбэр бөгөөд молхи байгальчийн бодлоор бол чухамдаа зөн совин буюу билэг сэрэхүй лүгээ хамаарах мэдрэмжийн эсвэр гарц буюу. Өнө эртнээс билиг совингийн талаар ярилцаар иржээ. Орчин үеийн физикийн сод туршилт хийгээд охь үзлийн өндөрлөгөөс эрдэмтэд төсөөллөө дэлгэсээр байна. XX зууны эхнээс хүмүүн бодисын гүн рүү нэвтэрч танихуйн их аянд мордсон юм. Тэр ертөнцийг өвөг монгол гэгээнтэн нар гүн билиг сэрэхүйгээр тандан багцаалж хумхи ертөнц хэмээн нэрэлбэр ч оноосон байж.

Квант жам. Хумхи ертөнц газрын хүмүүнд дадал болон хэвшсэн үлэг хорвоо, юмсаас тэс өөр хууль зүйтэй байсныг XX зууны эхнээс нээж нэвтэрч мэдэрсээр байна. Эл зүй жамыг Ньютоны сонгодог физикээс гоц ялгаатай квант физикээр илэрхийлнэ. Хумхи ертөнц буюу молекул, атом, атом, цөм түүний чинад хорвоод бүхий юмс, бүрэлдэл нь зааг ялгаатай мэт байх авч алс цараандаа хэрхэвч салгаж үл болох далд барилдлагатай нэгэн халуун амь оршихуй аж. Эл жамыг бүхий л Орчлонч чанад даган бүрэлдэн оршиж, бүрлэн хувирах аж.



Синергетик. XX зууны сүүлчийн мөчид цэгцэрч хөгжсөн синергетик эрдэм нь орчлон дахь аливаа юмс, үзэгдлийн хувьсахуйн язгуур учиг үзүүрийг хүмүүнд атгуулаад байна. Орчлонгийн алив хувьслын унги учир нь хуйларч, эвхэрч, мушигарахуйд өрнөдөг хаос үйлийг туулан цэгцрэхдээ баржиг (fractal) биежил бүрэлдүүлдэг зүй тогтолтой нь эрдмийн ертөнцөд хэдийн батжив. Газрын мануст ил харагдаж байгаа нь хуй хар салхи, уймрал, усны эргүүлэг бөгөөд баржиг нь бол уул, үүл, цасан ширхэг... мөн. Энэ бол ил баримт даруй мөн. Хүмүүн бид ч Орчлонгийн хуй эргүүлгэнд явнам. Дэлхий тэнхлэгээ эргэхэд газрын бид нэг секундэд 465м, нарны тойрууд 30 км, нарны аймагтай хамт Галактикийн төвийг тойрон 220 км хурдтай давхин эргүүлэг дунд явдаг аж.

Хаос ухаарлын төрүүлүүр. Тийм хуйлрал хувьсал нь математик хэлээр бол шугаман бус зүй жамтай. Шугаман бус гэдэг нь огторогуйн нэгэн цэгт, хугацааны нэгэн эгшинд нэг бус хэд хэдэн төрх шинж бүхий “хуйлрал” тохиох жамтайг хэлж байна. Яльгүй тодотговол сенергетик онол ёсоор аливаа хувьсал нь хуйлрал буюу хаос, үйлийг дамжин илүү төгс төгөлдөр бүтэц болон бас сэрэхүйг сонгож дэвших боломжтой юм. Нэгэн зэрэг тохиох олон хуйлрал төрхөөс илүү “төгс” нь шалгарч үлдээд дараах үеийн давталд үр хөвөрлийн эх нь болно. Энэ бол сонголт. Тэгэхлээр сонголт сэрж ухаарахуйн эх мөн болж таарах буюу.

Орчлонгийн алив хувьслын “хаос - бухимдал” төрх нь ухаарлын төрүүлүүр мөн буюу. Чингэж синергетик нь хувьслын язгуур үзлийн учиг үзүүрийг хүмүүнд атгуулаад байгаа юм. Орчлон хуйлран уймран хувьсах жамтайг билгээр тандан товллоод гүн билиг Мөнх Тэнгэр эрдмийг бадруулсан өвөг нүүдэлч монгол түмэн бол билиг совинд суурилсан эрдэм, соёлыг газарт анх түрүүнд мандуулсан байж шүү. Тэр эрчлүүр дундаас илүү төгс төгөлдөр нь шалгарч бүрэлдэх жамтайг дээд тэнгэрээс заяасан дээжис билиг шидээр мэдрээд “суу залиар” шалгаран цогцолж үлдэхийг тогтоосон байна. Мөнх Тэнгэрийн суу заль

бол эдүгэ цагийн тэрлэн буй синергетик лүгээ дүйх билиг эрдэм мөнийг онцлон тэмдэглэх нь зүйтэй хэмээнэм. Хүмүүн эдүгэ сэрж тэмүүлж буй тэр ид шидэт эрдмийг бадруулсан дээд тэнгэрээс заяат дээдсээрээ яахин үл бахархнам билээ.

Хувьслын жам. Совин сэрэхүй бол тэгэхлээр Орчлонгийн хувьслын үр бүтээл бөгөөд төгсгөлгүй тэмүүлэх хаос үйлийн өндөрлөх шат шатанд шигшигдэн төгөлдөржсөөр өнөөг хүрчээ. Анх 14 орчим тэрбум жилийн тэртээд Орчлон зүүний үзүүрээс ч нэн өчүүхэн гарагууд халуун нягтарлын дэлбэрэлтээр үүссэнийг суут Эйнштейн онолоор дэвшүүлж, олон туршилтаар нотолгоо нь одоо ч батажсаар байна. Анхандаа цөмийн тэртээх, удаагаар нь цөмийн, дараа нь атом, молекул бүрэлдэхүйд химийн, тэгээд уургийн амилаг үлэг нэгдэл төрөл олсноор биологийн, хожуу амь цэгцэрсний дараагаар сэрэхүй ухаарлын хувьсал шатлан дэвшжээ. Өнөөгийн байдлаар хувьслын оргилд хүмүүний оюун ухаан цэцэг нь болон дэлгэрээд байна. Чинагш ч бадарму...

Тэнгэрийн зарлиг. Базаж хэлбэл, оюун ухаарал бол Орчлонгийн хувьслын охь бүтээл мөн. Хүмүүн бид Орчлонгийн тэр бүтээлийн нэгээхэн шид хүч буюу сүнсийг Орчлонгийн ухаарал энерги мэдээллийн далайгаас “хувь хишиг” хүртэн тээж яваа, чухамдаа өмнө дурьдсан хувьслын бүхий л охь дээжсээр бүрэлдсэн газрын цогцос мөн. Орчлонгийн гэгээн ухаарал сэрэхүйн төлөөний сүнсийг тээж яваагаа мэдэхгүй, түүгээр ч үл барам, оюун ухаарал уураг тархи - материйн бүтээгдүүн мөн гэх үзэл өрнийн эрдэмд одоо ч амь бөхтэй хадгалаастай л байна.

Харин тэнгэрийн ухаарал сэрэхүйн сүнс оршихуй лугаа амьсан ний болоод Орчлонгийн жам зарлигийг сахин үндэстэн бултаараа тэнгэрийн нэгэн хүмэнд цэгцрэх заяаг өвөг дээдэс минь олоод, улмаар гайхамшигт үйл бүтээснийг эдүгэ дэлхий гайхсаар л бус уу. Нууцаа одоо ч хадгалсаар буй билиг совин унгит их соёлыг бадраан хүмүүний түүхнээ тэнгэр- хүмүүн-

байгалийн амин барилдлагаас урган цогцолсон тэнгэрийн “шоронгүй” засгийг газар дэлхий дээр анх хэрэгжүүлээд уудам орон зайд тогтоохыг зорьж аугаа үйлсийг хөгжөөсөн байнам.

Хөтөч үзлийн хувирал. Өмнө дурьдсан хоёр эрдмийн үзэл хийгээд орчин үеийн физикийн сод дэвшил оньс нь олдоогүй олон асуудлын шийдлийг шинэ төсөөлөл, таамнал руу хөтлөв. Юуны өмнө өрнийн шинжлэх ухааны Демокритээс эхэлсэн: Орчлон бол юмс, хоосон хоёроос тогтоно, юмсыг бутлаад байвал эгэл хялбар болно, хоосонд байх учир хоорондоо хамааралгүй байна гэдэг хөтөч үзлийг унгиар нь хувиргав. Квант физикийн үүднээс Орчлонгийн бүхий л юмс үл салах амин барилдлагатай. Чингэхүй эгэл хялбар, салангад юм гэж туйлаас үгүй. Амьсан ний болохуйд (wholeness) шинэ хөтөч үзэл (paradigm) өндөрт мандав. Эл амьсахуйн хөврөлийг үрслүүлж бадарсан физикийн ухааны өндөрлөгөөс совин сэрэхүй чухам юу болохыг цаашдаа тандах нөхцөл тохиох шинж байна уу?

Сод туршилт

Нэг. 1982 онд Францын физикч Аллен Аспектийн эрдмийн гал зууны гэдэг туршилт үйлдэж, газар дахь юмс (хүний бие)-ын нэг бөөмийг хөндөж цочроовол Орчлонгийн нөгөө хязгаарт ижил бөөмсдөө хол ойроос хамаарахгүйгээр эгшин зуур мэдээ хүргэхийг нотолсон юм. Та бидэнд юунаас ч хамаарахгүй тусгаар мэт харагдаж, тэмтрэгдээд байгаа юмс нь Орчлон лугаа “үл мэдрэгдэх” далд хатуу сүлбээтэй байх нээ. Тусгаар юм бүр бол сүүдрийг бодитой хэмээн үзэх лүгээ адил “хуурамч” бөгөөд мань ой ухаанд бууж бэхжсэн төөрөгдөл аж... Жинхэнэ юм гэвэл Орчлон лугаа амилан багцарсан их цараанд багтсан, хэрхэвч үл салгам аугаа ний заяатай байх нээ. Энэ бол өнөөгийн физикээс хийлж цэгцэрсэн гайхамшигт үнэн үзлийн учиг үзүүр яалтгүй мөн бөлгөө.

Хоёр. 2013 онд одод ертөнцийн судлаач 3 физикч Нобелийн шагнал хүртэв.

Орчлонгийн тэлж буй хурд удааширч эргэж хумиад дахин дэлбэрэх үйл тохиох болов уу хэмээн физикчид таамаглаад байсныг туршилтаар шалгажээ. Өөр өөр газар нутагт үйлдсэн тэдний туршилт Орчлонгийн тэлэлт удааших бус харин ч улам эрч аван хурдасч байгааг нотолжээ. Ямар учиртай бол оо?

Гурав. Одон орны физикчид туршилтаараа бас нэг гоц баримт олов. Харагдаж баригдах эд юмс, тэнгэрийн заадсын од гариг мэтийн масс нийлээд Орчлонгийн энерги массын дөнгөж 4 орчим хувийг эзэлж байгааг тогтоов. Суут Эйнштейн масс, энерги хоёр нэг амь юмны хоёр илрэл буюу угтаа хоёул эн тэнцүү нэг язгуур унгитайг нээсэн юм. Тэгвэл, бидний үл мэдрэх далд энерги юмс нь Орчлонгийн 96 орчим хувийг эзэлж байх нь. Тэрхүү далд оршихуйг мэдрэхгүй болохоор “хар энерги, хар нүх” гэж нэрлэж байна.

Тэр чинь үнэхээр бодитой юм уу? хэмээн сөргүү асуулт босно бизээ. Хар энерги бүх Орчлонг нэвтлэн газар сайгүй дүүргэн оршино. Эл далд энерги бидний дасаж мэдрэдэг 3D хэмжээст огторгуй чиндад газрын мэдрэмж, эрдэм ухааны арга чаргаас “нууц” далд оршино. Энэ нь Эйнштейний нээсэн Орчлонгийн энерги - массыг шингээсэн, огторгуй - хугацааны муруй-геометр бүрэлдлийн эрчлүүр хэмжээсэнд чинад хадгалаатай мэт төсөөлөгдөж байна. Тэгэхлээр та бидний бие цогцсын дийлэнхийг тэр хар энерги эзэлж буй шүү дээ. Чингэхүй Орчлонгийн ил юмс бол хар энергийн хувьд тув тунгалаг буюу дотроо ч гаднаа ч хориогүй хар энергийн далайд живж, эрхэнд нь байх зуурдын бүрэлдэл мөн. Эндээс өлгөж бодвол хар энерги мань 3D орчлонгийн гадаадад тэгсэн мөртлөө бүхнийг тунгалаг нэвтлээд эзэгнэн байх аж. **Хар энерги - амь оршихуй.** Савтай хий, шингэнд гаднаас энерги өгч халаавал тэлнэ, буудна, дэлбэрнэ. Тэгэхлээр хар энерги Орчлонд тиймэрхүү л үүрэг гүйцэтгэж байж мэдэх нь. Тэгээд л хурдсан тэлдэг л болов уу даа. Далд хар энерги бол Орчлонгийн бүр язгуур амь оршихуй л болж таарч байна.

Скалар долгио. Физикчид цахилгаан



соронзон долгионы давших долгио буюу скаляр долгиог шинээр илрүүлэв. Амьдрал практик, цэрэг дайны зорилгоор ашиглах эрэлт, хайлт хийж, гар хоосонгүй л байгаа бололтой. Энэ төрөл долгионыг XX зууны эхэнд Сербийн инженер Тесла нээж алс зайд утасгүйгээр энерги дамжуулах боломжтойг нотолж байжээ. Гэвч анзааралгүй орхигдсон нь цагаасаа түрүүлсэн эрдэмтний бүтээл тийм жамтайг илтгэнэм буюу.

Цахилгаан соронзон долгио бол соронзон Н, цахилгаан Е вектор нь тархах чигт хөндлөн хувирч нэг нь буурахад нөгөө үүсдэг жамтай. Техник технологи үүнд суурилан хөгжиж, хүмүүний нийгмийг хол давшуулсан юм. Эсрэг фазтай буюу хотгор гүвгэр нь эсрэг тохиосон 2 долгио нийлэхүйд “оргүй” болж усталцана хэмээн үзсээр ирсэн юм. Гэтэл хоёр хөндлөн долгио уталцахад тархах чиг дэх дагуу долгион үлддэгийг илрүүлэв. Эдүгэ хүртэл мэдэрч тэмтэрч чадаагүй эл далд долгиог скаляр долгио хэмээж байгаа юм.

Скаляр долгио нь эсрэг фазтай 2 цахилгаан соронзон долгион нийлэхээс гадна мөн эсрэг чиглэлтэй хувьсах гүйдэл гүйж байгаа дамжуулагчийн орчинд бас үүсдэг. Энэ долгион нь бидний оршин буй 3D огторгуй бас хугацааны чинадад өмнө өгүүлснээр бүхнийг тунгалаг нэвтрэн оршино. Тиймээс өнөөг хүртэл шинжлэх ухаан илрүүлж чадалгүй явжээ. Скаляр долгио бол 3D огторгуйн чинадад гагцхүү хугацааны хувьд мэдээлэл-энергийн долгион гэж үзэж байгаа юм. Нөгөөтэйгүүр, скаляр долгио бол газар тохиосон үйл хувирлаар үүссэн цахилгаан соронзон долгионууд нийлэхдээ үүсгэдэг холограф буюу мэдээллийг бүгдийг багтаан цэгцэрсэн ширээс- холограф үүсгэнэ. Хугацааны долгионыг гагцхүү скаляр энерги л тээж Орчлонд үе давхаргаар (долгиог) нь хадгална. Чингэхүй тэр скаляр мэдээлэл-энергийн долгиолог гурван цаг буюу өнгөрсөн, одоо, ирээдүйн мэдээллийг хаа сайгүй бүтнээр нь хадгалж буй холограф гэж үзэж байгаа юм. Хар энерги, хар бие, скаляр долгио бол нэгэн төрөлд багтах холограф мөн буюу гэх санаа молхи намайг эзэмдэнэм.

Физикийн энэ ололт үзэл нь далд ухамсар буюу зөн совинд хэрхэн холбогдох вэ? гэдэг асуудал гарч болно.

ДНХ ба далд ертөнц. Удамшлын мэдээллийг тээгч ДНХ молекул хоймсон мушгиа бүхий ярвигтай ний бүтэцтэй. Эсийн доторх физик, химийн хувирал нь эцсийн эцэст хувьсах цахилгаан дохио (гүйдэл)-той шууд холбоотой болох нь эдүгэ тодорхой болжээ. Хоймсон мушгиа дундуур эсрэг чиглэлтэй гүйдэл дамждаг болов уу хэмээн молхи физикч төсөөлж явна. Чингэхүйд ДНХ үлэг молекул нь газарт тохиож бүрэлдсэн мэдээллийг өмнө ярьсаар буй далд буюу Орчлонгийн хар, скаляр энерги- мэдээллийн далай руу нийлүүлдэг бас тэндээс мэдээллийг авч ил ертөнц рүү наашлуулдаг шид чадалтай байж таарч байна. Тэгэхлээр хүний бие цогцос дахь барагцаалбал 10^{14} тооны ДНХ, хромосом нь илийн сэрэхүй хийгээд Орчлонгийн оройн дээд ухаарал-далд ертөнцийн хооронд мэдээ харилцааг барих “гүүр” мэт үүрэгтэй буюу. Удамшлын ДНХ молекулыг тээсэн ургамал, адгуус амьтан ч ялгаагүй л билиг чадвартай байх. Загас, шувуу, амьтад сүргийн билиг чадвар илрүүлж, сүргээрээ гайхамшигт хам төрх шинж, уран хөдөлгөөн үйлддэг нь билиг мэдрэмж буюу далд ухамсрын илрэл гэж үзэх үндэстэй мэт. Тэнгэрийн нэгэн хүнд цэгцэрсэн өвөг нүүдэлч түмэн бол дээд тэнгэрийн буюу Орчлонгийн хувьслын оройн дээд ухаарлын жолоог атгахад олсон заяаны илрэл мөн гэхээс өөр юу байхав дээ.

Билиг ба сүнс. Сүнс байгааг хүмэн ухаарсан тэр цагаас инагш ярьсаар ирсэн боловч харсан, тэмтэрсэн нь нэгч үгүй болохоор далд ертөнцийн оршихуй мөн бизээ. Өмнө өгүүлснээс үзэхүл, сүнс тэнгэр буюу далд ертөнц лүгээ ний болж мэдээлэл авах шид чадал олдог хүнийг гэгээтэн, зайран, удган, зөнч, билиг танхай эрдэмт гэж нэрлэж ирсэн байна. Тэнд хүрэх арга зам нь байгаль, цаг уур, нийгмийн төлөвшил, соёл, үндэстний гарвал унги, хувь хүний билиг мэдрэмжээс хамааран орон нутаг бүрт өөр өөр байх нь мэдээж.

Хамгийн гол нь гадаад орчин,

нийгэм, ахуйн дарамт мэдээллээс салж, дотоод ертөнц рүүгээ ний болбол бүхий л биеэр тунгалаг- нэвчсэн далд ертөнцийн мэдээлэлд шууд холбогдох боломжтой юм. Чингэхүйд гэгээнтэн, зөнч нь орчлонгийн хувьслаар бүрэлдсэн дээд гэгээн сэрэхүй ухаарал руу ний болоод, хүлээн авснаа мэдрэхүйн системдээ боловсруулаад совин мэдээ хэлдэг байх. Тийм зөнч, увидистан хүмүүний түүхнээ тоо томшгүй төрсөн бизээ. Сод төлөөлөгч нь Да Будда, Нагар Жунай, Нострдамус, тун саяхных нь Ванга эмгэн мөн. Чингис хааныг энэ зэрэгт багтах зөнч байсан болов уу, тиймээс ч үндэстний билиг сэрэхүйг тэнгэрийн ухаарлын жолоонд хүргэж “найруулах” ид шидийг хэрэгжүүлсэн байх гэх бодол молхи байгальчид төрдгийг ч хэлсү. Дээд гэгээн сэрэхүй нь техникт багажид өртөж илрэхгүй, харин Орчлонгийн хувьслын оройн дээд цэцэг-хүмүүн билиг чадлаар мэдэрч болдгийн нотолгоо нь дурьдсан баримтууд мөн хэмээнэм.

Шигшэхүй. Эцэст тэнгэрийн дээд гэгээн-ухаарал сэрэхүй бол орчлонгийн хувьслын дээжис бүтээл мөнийг физик, сиергетик эрдэм сануулж байна. Тэр нь өнөөгийн шинжлэх ухааны мэдрэх таних чадвар хийгээд бидний дадсан огторгуй хугацааны алс чинад дахь оршихуй аж. Газрын хүмүүн бид Орчлонгийн дээд гэгээн ухаарлын нэгэн бүрэлдүүн сүнс энерги- мэдээллийг газарт тээж, ухаалаг сайн үйлсийг бүтээх заяаг өвөрлөсөн тэнгэрийн төлөөний амьтан гэдгээ мартах ёсгүй юм.

Сүнс тэнгэрт дээдсийн онгод далд ертөнцөд илүү гэгээнлэг “нийхэм” болон оршиж байж ч мэдэх юм. Ариун онгодоос асууж, сурч, ил, далдын тухай мэдээ, мэдлэг олж, сайн үйлсийг бүтээж байсан хувьтай ард түмэн бол гагцхүү өвөг монголчууд гэдгийг санаж явбал илүүдэхгүй. Өнөөгийн бид өвөг дээдсийн гэгээн чадлыг ихэд гээжээ. Эдүгэ хүмүүн төрөлхтөн тэр шид чадварыг мэдэрч эзэмдэхийн төлөө чармайх болов. Цаг ирнээ...

Адгуус мэт явбаас сүнсний чансаа адгуусны төвшин рүү уруудах учир насан

халихуйд далд ертөнц дэх хүмүүний сүнсний “нийхэм” тэнгэрт буцах орон зай олдохгүй болно. Чухамдаа хүмэн бол орчлонгийн дээд ухаарал, сэрэхүйн амь эд эс нь ч буюу. Энергийн адил сүнс-мэдээллийн хадгалагдах нь ил, далд ертөнцийн харилцаа барилдлагын жам болов уу. Орчлонгийн дээд ухаарал сэрэхүйн шалгуур нь тэнгэрийн түгээмэл шударга ариун зарлигийг дагадаг нь жам юм. Мөнх Тэнгэрийн хүч бол чухамдаа 3D огторгуйн чинад дахь дээд ухаарал хийгээд сүнс далай лугаа ний болж язгуур эрдэм, мэдээллийг билиг сэрэхүйгээр авах үйл хэмээн төсөөлнөм. Мөнх Тэнгэрийн хүч ивээтүгэй!

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Лхагва, О. (2010). Цэгээн шар хүн хэн бэ. “Acta Mongolica”, Vol.9(320), 227-232.

Лхагва, О. (2012). Мөнх Тэнгэрийн хүчинэй үндсийг бэдрэхүй. *Universe of Knowledge(Academae)*, 37-46

Лхагва, О. (2013). *Орчлон, суу заль, Мөнх Тэнгэр*. Монгол: Битпресс